

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААН – Хуралдааны тойм

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦСЭН АСУУДЛЫН ХӨТӨЛБӨР № 10

Хуралдаан 2013 оны дөрөвдүгээр сарын 11-ний өдрийн 9 цаг 00 минутад эхэлж, 11 цаг 20 минут хүртэл Төрийн албаны зөвлөлийн хуралдааны танхим (Засгийн газрын 11 дүгээр байрны 301 тоот өрөө)-д болж, нийт 2 цаг 20 минут үргэлжлэв.

№	Хэлэлцсэн асуудал	Гарсан шийдвэр
1	Архангай аймагт зохион байгуулсан Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилго бүхий төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, уг шалгалтанд тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, бүртгэгдсэн иргэдээс онооны дарааллыг баримтлан өрсөлдсөн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 56 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Архангай аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн Норовын Чимэгбаярыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. 2013 оны 04 дүгээр сарын 02-ны өдөр Архангай аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн Норовын Чимэгбаярыг “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэж, өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх.</p> <p>2. Норовын Чимэгбаярыг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар</p>

		<p>зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан тухайн албан тушаалд нь томилохыг эрх бүхий албан тушаалтанд тус тус үүрэг болгох.</p> <p>3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын дарга Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
2	<p>Хууль зүйн яам, Жендерийн үндэсний хороо, Газрын харилцаа, геодези, зураг зүйн газраас зохион байгуулсан Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоог нөхөх зорилго бүхий төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтын дүн, уг шалгалтанд тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албанд анх орох иргэний нөөцийн жагсаалтад бүртгэж, бүртгэгдсэн иргэдээс онооны дарааллыг баримтлан өрсөлдсөн албан тушаалд нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 56 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр зохион байгуулсан Хууль зүйн яам, Жендэрийн үндэсний хорооны сул орон тоог нөхөх Төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн иргэдийг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн нийт 12 иргэнийг “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэснийг 1 дүгээр хавсралтаар батлах.</p> <p>2. Энэхүү тогтоолын нэгдүгээр зүйлд заасан “Дэс түшмэлийн ангиллын төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэгдсэн иргэдээс хамгийн өндөр оноо авсан 4 иргэнийг тус тусын өрсөлдсөн албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлснийг 2 дугаар хавсралтаар батлах.</p> <p>3. Энэхүү тогтоолын хоёрдугаар хавсралтаар баталсан нэр бүхий 4</p>

		<p>иргэнийг “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д заасан шаардлагыг баримтлан тус тусын албан тушаалд томилохыг тухайн эрх бүхий албан тушаалтанд үүрэг болгох.</p> <p>Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
3	<p>2013 оны 3 дугаар сарын 16-17-ны өдөр Увс аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтанд тэнцсэн О.Түмэнжаргалыг нөөцөд бүртгэн, нэр дэвшүүлэх тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3, Төрийн албаны зөвлөлийн 2009 оны 63 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны мэргэшлийн шалгалт авах журам”-ын 56 дугаар зүйлийг баримталж, 2013 оны 03 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Увс аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн Оршихын Түмэнжаргалыг төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд бүртгүүлэх тухай Төв комиссын саналыг хэлэлцсэн Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн :</p> <p>1. 2013 оны 03 дугаар сарын 16-17-ны өдрүүдэд Увс аймагт зохион байгуулсан төрийн албаны мэргэшлийн шалгалтад тэнцсэн Оршихын Түмэнжаргалыг “Төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөц”-д бүртгэж, өрсөлдсөн албан тушаалд нь томилуулахаар нэр дэвшүүлэх.</p> <p>2. Оршихын Түмэнжаргалыг, “Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль”-ийн 23 дугаар зүйлийн 23.5, Төрийн албаны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.1-д</p>

		<p>заасан шаардлагыг баримтлан тухайн албан тушаалд нь томилохыг эрх бүхий албан тушаалтанд тус тус үүрэг болгох.</p> <p>3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн гишүүн, Төрийн албаны мэргэшлийн шалгалтын төв комиссын дарга Т.Хадхүүд даалгах тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
4	<p>Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа, нийтлэг үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны сонгон шалгаруулалтын тайлан, уг албан тушаалд томилогдох ажилтанд дүгнэлт гаргуулах тухай</p>	<p>Төрийн албаны тухай хуулийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 32, 34, 39 дүгээр зүйлүүдийг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>1. Батаагийн Цэвээнпүрэв, Наранчулууны Отгончимэг нарыг Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа, нийтлэг үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн даргын албан тушаалд томилогдох төрийн жинхэнэ албаны удирдах ажилтны нөөцөд бүртгэх.</p> <p>2. Энэ тогтоолын 1 дүгээрт нэр заасан иргэдээс Батаагийн Цэвээнпүрэвийг Монгол Улсын Их Хурлын Тамгын газрын Захиргаа, нийтлэг үйлчилгээ хариуцсан нарийн бичгийн даргын албан тушаалд томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Улсын Их Хурлын Тамгын газрын ерөнхий нарийн бичгийн дарга Б.Болдбаатарт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>

<p>5</p>	<p>Хууль зүй яамны зарим газар (2)-ын даргын албан тушаалд томилуулахаар санал болгосон албан хаагчид Төрийн албаны зөвлөлийн дүгнэлт гаргаж, нэр дэвшүүлэх тухай</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн захиргааны удирдлагын газрын дарга - Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга 	<p>Төрийн албаны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.4, 35 дугаар зүйлийн 35.1.6 болон Улсын Их Хурлын 2003 оны 13 дугаар тогтоолоор баталсан “Төрийн жинхэнэ албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ын 14-ийн “б”-д заасныг тус тус баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн:</p> <p>Хууль зүйн яамны Төрийн захиргааны удирдлагын газрын даргын албан тушаалд Нэргүйн Мягмарыг, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын даргын албан тушаалд Оюунсайханы Алтангэрэлийг тус тус томилуулахаар дүгнэлт гарган нэр дэвшүүлж, Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Баярцэцэгт санал болгох тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
<p>6</p>	<p>Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны зарим газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай:</p> <ul style="list-style-type: none"> -Төрийн захиргааны удирдлагын газар -Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга -Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газрын дарга -Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын дарга 	<p>Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ж.Батболдын 2013 оны 3 дугаар сарын 29-ний өдрийн 3/1365 тоот албан бичиг, ажлын байрны тодорхойлолтоор, Байгаль орчин, ногоон хөгжлийн яамны Төрийн захиргааны удирдлагын газар, Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар, Ногоон хөгжлийн бодлого, төлөвлөлтийн газар, Тусгай хамгаалалттай нутгийн удирдлагын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу эдгээр албан тушаалд томилогдох удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг 2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг</p>

		2013 оны 05 дугаар сарын 01-02-ны өдөр зохион байгуулахаар тогтов.
7	Хууль зүйн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байрыг нийтэд, нээлттэй зарлах тухай	Хууль зүйн яамны Төрийн нарийн бичгийн дарга бөгөөд Хууль зүйн яамны дэргэдэх Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн дарга Ж.Баярцэцэгийн 2013.03.29-ний өдрийн 1/8 тоот албан бичиг, ажлын байрны тодорхойлолтоор Хууль зүйн яамны Хяналт шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газрын даргын албан тушаалд томилогдох удирдах ажилтны ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлуулах тухай захиалга Төрийн албаны зөвлөлд ирсний дагуу энэ албан тушаалд томилогдох удирдах албан тушаалтны сонгон шалгаруулалтыг 2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс Төрийн албаны зөвлөлийн цахим хуудсаар нийтэд нээлттэй зарлаж, сонгон шалгаруулалтыг 2013 оны 05 дугаар сарын 01-02-ны өдөр зохион байгуулахаар тогтов.
8	Төсвийн байгууллагын төсвийн шууд захирагч (дарга, захирал, эрхлэгч)-ийн албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам	Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.4.18, Төрийн албаны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 болон “Журам батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2003 оны 5 дугаар сарын 8-ны өдрийн 13 дугаар тогтоолыг баримталж, Төрийн албаны зөвлөлийн 2013 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн хуралдааны шийдвэрийг үндэслэн: 1. “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг сонгон шалгаруулах журам”-ыг нэгдүгээр, “Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтны сонгон шалгаруулалтын үнэлгээ, дүгнэлт гаргах заавар”-ыг хоёрдугаар, сонгон шалгаруулалтын дүнгийн хуудсыг гуравдугаар, шалгалтын нэгдсэн үнэлгээний хуудсыг дөрөвдүгээр, шалгалтын тайлан, мэдээ ирүүлэх хуудсыг тавдугаар хавсралтаар тус тус батлах.

		<p>2. Төрийн үйлчилгээний албаны удирдах албан тушаалд томилогдох ажилтныг шалгаруулахдаа энэхүү журам, зааврыг баримталж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн салбар зөвлөл болон аймаг, нийслэлийн Боловсролын газарт үүрэг болгох.</p> <p>3. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Төрийн албаны зөвлөлийн 2003 оны 13 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох.</p> <p>4. Энэхүү тогтоолыг 2013 оны 04 дүгээр сарын 11-ний өдрөөс мөрдөх тухай Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
9	Төрийн албаны зөвлөл түүний Ажлын албаны төрийн нууц хамгаалах дотоод журамд өөрчлөлт оруулах тухай	<p>Монгол Улсын Төрийн нууцын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 3, Байгууллагын нууцын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1, Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5, Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 213 дугаар зарлигаар баталсан "Монгол Улсын Төрийн нууцыг хамгаалах журам"-ын 1.5-д заасныг үндэслэн:</p> <p>1. "Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, түүний Ажлын албанд төрийн нууц хамгаалах дотоод журам"-ыг 1 дүгээр, Төрийн нууцад хамаарах бусад мэдээ, мэдээлэл, баримт бичиг, биет зүйлстэй танилцах эрх бүхий албан тушаалтны жагсаалтыг 2 дугаар хавсралтаар тус тус батлах.</p> <p>2. Монгол Улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 213 дугаар зарлигаар баталсан "Монгол Улсын төрийн нууцыг хамгаалах журам"-ын дагуу хэрэглэгдэж байгаа маягтуудыг өөрийн байгууллагад мөрдөх, "Төрийн нууц хамгаалах дотоод журам"-ыг зохион байгуулахдаа хөтөлж ажиллахыг нууц хариуцсан ажилтанд үүрэг болгох.</p> <p>3. "Төрийн нууц хамгаалах дотоод</p>

		<p>журам"-ыг холбогдох ажилтан, албан тушаалтнуудад мэдүүлж мөрдүүлэх, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Ажлын албаны дарга /С.Цэдэндамба/-д үүрэг болгох.</p> <p>4. Энэхүү журам батлагдсантай холбогдуулан Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн даргын 2003 оны 18 дугаар тушаалаар батлагдсан "Монгол Улсын Төрийн албаны зөвлөл, түүний Ажлын албанд төрийн нууц хамгаалах дотоод журам"-ыг хүчингүй болсонд тооцох.</p>
10	Сургалт, судалгаа, үйлчилгээний төвийг байгуулах тухай зөвлөх өөрчлөн	<p>Монгол Улсын Төрийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйлийн 34.13 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын 2009 оны 87 дугаар тогтоолоор баталсан "Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм"-ийн "Гурав"-ын 3.8 дахь хэсэгт тус тус заасныг үндэслэн Монгол Улсын Төрийн албаны зөвлөлөөс тогтоох нь:</p> <p>1. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх "Сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний төв"-ийн нэрийг "Төрийн албаны институт" болгон өөрчлөх.</p> <p>2. Монгол Улсын Төрийн албаны зөвлөлийн дэргэдэх "Төрийн албаны институт"-ийн дүрмийг хавсралтаар батлах.</p> <p>3. Төрийн албаны зөвлөлийн 2010 оны 05 дугаар сарын 18-ны өдрийн 78 дугаар тогтоолыг хүчингүй болсонд тооцох тухай Монгол Улсын төрийн албаны зөвлөлийн тогтоол гаргахаар тогтов.</p>
11	Бусад асуудал: - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, ИТХ-ын нарийн бичгийн даргын ажлын байрны тодорхойлолтод хийсэн харьцуулалт	<p>Аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга, ИТХ-ын нарийн бичгийн даргын ажлын байрны тодорхойлолтод хийсэн харьцуулалтыг хэлэлцээд, хуралдаан дээр гарсан саналыг тусгах, Засгийн газарт хүргүүлэн танилцуулах, ажлын байрны тодорхойлолтоо аймгууд</p>

		руу явуулж танилцуулах нь зүйтэй гэж үзэв.
--	--	--

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ